

НИЙГМИЙН ИННОВАЦИ

МОНГОЛЧУУДЫН НҮҮДЛИЙН МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЛААРХ НЭГЭН ХАНДЛАГА

Б. Наранбаатар
Докторант

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

philosophy@must.edu.mn

Хураангуй: Монголчуудын мал аж ахуйгаа эрхлэн хөтлөх хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэр нь хот айлаас суурь, хэсэг, бригад, нэгдэл, малчдын бүлэг зэргээр хэмжээ, өмчлөлийн хэв маяг нь өөрчлөгдсөөр ирлээ. XX зуунд явагдсан энэ үйл явц 3 үндсэн үеүдэд хуваагдана. XX зууны эхний хагаст гадаадын мөнгө хүүлэл, капиталын ноёрхлыг зогсоож нэгдэлжих хөдөлгөөн өрнөх нөхцөлийг бүрдүүлсэн. XX зууны 2-р хагаст нэгдэлжих хөдөлгөөн ялж социалист үйлдвэрлэлийн системд нэгдэн орсон. XX зууны сүүлийн хагаст нэгдэл тарж хувийн мал аж ахуйтнууд үүссэн. Үе бүр үйлдвэрлэлийн хэрэгсэлд хандах өмчийн харилцааны онцлогтой. МАА-н үйлдвэрлэлийн таваарлаг чанарыг дээшлүүлэхэд мал, малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид дээд эрэмбийн зорилтын хүрээнд хөдөлмөр зохион байгуулалтын дараах хэв маягууд үүссэн. Жасын хөрөнгө арвижуулах, сүм хийдийн хэрэгцээт зүйлийг бэлтгэх жасын малчид, ЗХУ болон ТУХН-ийн орнуудын тусламжтай баригдсан үйлдвэрийн стандартад нийцсэн мал, малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх нэгдлийн гишүүд малчдын суурь, бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх малчдын бүлгүүд зэрэг юм. Өнөөгийн нээлттэй харилцаанд биржийн худалдаа, кластер зэрэг бэлтгэн нийлүүлэгч малчид ба үйлдвэрлэгчдийн хоорондын харилцааны олон боломжууд бий болсоор байна. Ийнхүү дээд ба дэд эрэмбийн харилцаанд уламжлалт үнэт зүйлс болох харилцан итгэлцэл ба өмчийн харилцааны онцлог бэлчээрийн зохистой ашиглалтыг хангаж, МАА-н үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нөлөөллийг судлахаар зорилоо.

Түлхүүр үгс: Дээд ба дэд эрэмбэ, харилцан итгэлцэл, нийтлэг нөөц, үйлдвэрлэлийн хэрэгсэл, ажиллах хүчний нөөц, кластер

УДИРТГАЛ

Нийгэм-эдийн засгийн байгууллын тухай Марксист онолоор хүн төрөлхтний нийгмийн түүхийг хүй нэгдлийн, боол эзэмшлийн, капиталист, коммунист нийгэм гэсэн үе шатаар хөгжиж байгаа ба нийгмийн хөгжлийн хамгийн дээд шат бол коммунизм

болох юм. Энэ үе үйлдвэрийн хэрэгслийн өмчийн харилцаанд дайсагнагч эсрэг тэсрэг ангигүй, дарлал мөлжлөггүй, бүгд тэгш эрхтэй шударга ёс тогтоно гэдэгт үндэслэдэг. Үйлдвэрлэлийн хэрэгсэл нь феодал нараас хамжлага, шавь ардын хүч хөдөлмөрийг мөлжих хэрэгсэл

гэвэл түүхэн баримтаар няцаагдаж байна. Монголын нүүдлийн нийгмийн бүтцийг бүрдүүлэгч ангиудын хоорондын харилцаа дайсагнасан эвлэршгүй тэмцэл бус харилцан итгэлцэлд тулгуурлана. Өмчийн хувьд үйлдвэрлэлийн хэрэгслээр дамжуулан мөлжлөгийн хэрэгсэл болдог талтай ч газрын эзэн нь угсаа залгамжлагч ноён, тайж, жас бүхий шавь, хутагтууддаа харьяат ардууд нь ёс суртахууны сайн дурын үндсэн дээр захирагддаг онцлогтой. Харьяат ардууд зайлшгүй төлөх алба, татвараа барагдуулсан л бол аж ахуйн үйл ажиллагааг өөрийн дураар эрхлэн явуулж бод малыг аян жин тээх, нүүдэл хийх, сүм дуганы мод чулуу, түлээ бэлдэх зэргээр хөдөлмөрийн хэрэгсэл болгон ашиглана (Дашпүрэв. Д. , 2017).

Нийлүүлэлтээс хэт хамааралтай, өөрийгөө аргацаасан эдлэхүүний аж ахуй бүхий, техникийн шинэчлэлд бага өртдөг экстенсив шинжтэй, шинэ арга барил, технологийн ололтыг нутагшуулах чадвар бага, хөдөлмөрийн хуваарь төрөлжин нарийсаагүй зэргээр уг ахуйн хөгжлийн шалгуурыг суурин аж ахуйн хүрээнд боловсрогдсон дээрх онолын хандлага өдгөө ч цухалзсаар байна.

Үйлдвэрлэлийн хэрэгслийг ашиглах, эзэмших эрх нүүдлийн МАА эрхлэгчдэд ямар онцлогтой байдаг, энэ эрх хангагдсанаар ашиглагч талдаа хөдөлмөрийн эрх

чөлөө өргөжүүлж ирсэн түүхэн баримтыг тогтоосноор хамтач аж ахуйн нийгэмч хөдөлмөрийг нэгдэлжих хөдөлгөөнөөр хязгаарлалгүй уламжлалт нийгмийн аж ахуйн үндсэн бүтэц болох хот айлын зохион байгуулалтын эерэг талуудыг харгалзсан аж ахуйн зохион байгуулалтын бүтцийг таамаглах боломжтой гэж судлаач үзэж байна.

ОНОЛ, АРГА ЗҮЙ

Системийн онолын үүднээс аливаа систем өөрийн багтаж орж байгаа дээд эрэмбийн системдээ тодорхой үүрэг гүйцэтгэдэг тэгш хэмт бус шинжтэй. Харин дээд эрэмбийн систем тэрхүү дэд системийнхээ тэнцвэрт бус байдлыг нөхөн гүйцээж байгаа хир хэмжээгээр тэнцвэрт байдалтай. Үүнийг тэнцвэрт бус тогтвортой байдал гэнэ. “Ийм тэнцвэрт тогтолцооны жишээ нь хүн-мал-бэлчээр юм (Хавх., 2000).” Аль ч түвшний систем орчин, эерэг ба сөрөг буцах холбоос бүхий байна. Эерэг буцах холбоос нь уг зүйлийн орчны нөлөөллийг хүлээн авч түүнд дасан зохицох буюу үүргийн тал нь нарийсаж дагнадаг. Гэвч энэ талын дагналт эргээд системийг бүрдүүлэгч элементүүдийн тогтсон харилцааг өөрчлөх, цаашлаад эмх цэгцгүй болгох ч талтай. Сөрөг буцах холбоос нь орчны өөрчлөлтөөс системийн хамаарлыг багасгах, бүрдүүлэгч элементүүдийн харилцаа холбоог олон талтай болгох замаар

тогтвортой байдлаа хадгалдаг. Бүтцийн харьцангуй бие даасан байдал нь системийн элементүүд орчны боломжит өөрчлөлтийг хүлээн авах замаар чиг үүргээ харилцан орлох чадварыг олгодог. Амьд организм орчны өөрчлөлтийг хүлээн авч дасан зохицохын зэрэгцээ түүнээс хамаарах хамаарлыг багасгахын тулд өөрчлөлтийг тосон хариуцах урьдач хүртэхүй бүхий ой санамжтай байдаг нь эерэг, сөрөг буцах холбоосны харилцааг харуулж байна.

Нийтлэг нөөцийн ашиглалтын зохистой хэмжээ нийтийн эзэмшлийн өмчийн харилцаанд үндэслэдэг учраас нөөцийг харилцан адилгүй ашигласнаас үүдсэн ашгийг тооцох боломж байдаггүй (Ostrom, 1961). Иймд харилцан итгэлцэлд тулгуурладаг. Монголд ямаагаа өсгөснөөс үүдсэн бэлчээрийн доройтолд хэн ч хариуцлага хүлээдэггүй билээ. Учир нь “Би ямаагаа багасгавал бусад нь илүү ашиг олно” гэсэн хардлага, үл итгэлцэл байгаа учраас бүгд л ямаагаа өсгөөд нийтлэг нөөц болох бэлчээр нь сүйдээд дээр нь уур амьсгалын өөрчлөлт давхар нэрмээс болж байна. Иймэрхүү үл итгэлцэл уг системийнхээ тухайн эрэмбийн чанарын бус тооны өөрчлөлтийг л нөхцөлдүүлж байна.

Ямар ч түвшний зохион байгуулалт бүхий нийгэмлэгийн гишүүд нийгмийн статусаас хамаарч эдэлж байгаа эрх зарим төрлийн эрх чөлөөнөөсөө

татгалзахад хүргэдэг. Хувь хүний эрх чөлөө нь нийгмийн гишүүдийн тэгш эрхийн зарчимтай нийцэшгүй гэж үздэг. Томас Хоббс “... хүн бүр тэгш эрхтэй төрж, эрх чөлөө, аз жаргалыг эрэлхийлэн хүсэх эрхтэй ч өөрийн эрх чөлөөг хязгаарлахгүйгээр тэр хүслээ эдэлбэл бие биетэйгээ гарцаагүй сөргөлдөнө (Батцэрэн Ц., 2019). Тэгш бус байдлаас үүдэлтэй эрх чөлөөг дээдэлбэл бие биеийнхээ эрх чөлөө эдлэх боломжийг хязгаарлах тул ядахлаа хүн бүрд сонголт хийх тэгш нөхцөлийг бүрдүүлэх нь зүй ёс буюу шударга хуваарилалт юм. Хувь хүний тэгш эрх эсвэл тэгш боломжийг дэмжин явуулж буй төрийн арга хэмжээ бүр эрх чөлөөг нэмэгдүүлдэг бол, “бүх хүнд шударгаар хуваах” -ын төлөө явуулж буй төрийн бодлогын үр дүн эрх чөлөөг хумина (Батцэрэн Ц., 2019).

Тиймээс ямар ч түвшний нийгэмлэгийн гишүүний хувьд эрхээ эдлэх нь нийгэмлэгийн тэргүүний нийтийн санг хуваарилах эрх мэдлийг хүлээн зөвшөөрч эрх чөлөөний хязгаарлалтад баригдана гэсэн үг. Нийтийн сангийн хүртээмж нь бүгдэд нээлттэй, тэгш эрх буюу нийгмийн боломж ба хуваарилах эрх мэдлийн зохистой харьцаа учраас итгэлцэлд үндэслэгдэнэ. Монголчуудын бэлчээрийн мал ахуйн хэвийн оршин тогтнол байгалийн саад бэрхшээлийг давах, бэлчээрээ хамгаалах, тэлэх зэрэг нь тусдаа салангид аж ахуйгаас хэтийдсэн

зорилт учраас хувийн явцуу эрх ашгийг хангах, ашгийн хойноос улайран хөөцөлдөх бус харилцан итгэлцэл, туслалцах зэрэг илүү дээд эрэмбийн зорилтын хүрээнд хангагдаж иржээ.

Нэгдэлжих хөдөлгөөний өмнөх, оргил болон дараах үеүүдийн харилцан итгэлцэл ба хяналт

Дээд эрэмбэ буюу эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үе шатны хэвийн ажиллагааг хангахын тулд доод эрэмбийн үе шатны буюу бэлтгэн нийлүүлэлтийн тоо хэмжээг хянах шаардлагатай. Энэ нь үйлдвэрлэлийн хэрэгслийн нийлүүлэлтийн хэмжээ, онцлогоор илэрнэ. Үйлдвэрлэлийн хэрэгслийг ашиглах, эзэмших эрх нь тухайн үйлдвэрлэлийн аргын хүрээний нөхцөл боломжийг ашиглан үйл ажиллагааны эрх чөлөө байдлаар хэрэгждэг. Тухайлбал, Монгол орны хойд болон өмнө хилийн томоохон худалдааны боомт хотуудын ойролцоо жин тээгчдэд агуулах сав, мөнгө зээллэг, агуулах хашаа, бод малын агуулах жүчээ бүхий аж ахуйтнууд үүсэж суурин газрын харилцаа үүссэнээр тэд гэрээт малчин бүхий капиталист аж ахуйн үүслийг тавьсан.

Нэгдэлжих хөдөлгөөнөөс өмнөх үеийн харилцан итгэлцэл ба хяналт

Монголын уламжлалт нийгмийн тогтвортой бүтэц бол өрх буюу өрх гэр юм. Өрх гэр²⁷ нь дотроо хэд

хэдэн гэр бүлийг багтаасан байж болно. Нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн явцад нэг өрх эсвэл хэд хэдэн өрх нийлж айл гэсэн бүтцийг үүсгэнэ. Тэр нь өөрийнхөө ээлжинд хот айл, зарим тохиолдолд саахалт айлуудыг үүсгэнэ (Дашпүрэв. Д. , 2017). Мал маллагааны аж ахуйн зохион байгуулалт нь хот айл болдог ба өрхийн тэргүүн нь ахмад, туршлагатай нь байх ч заримдаа өрхийн ууган хүүг болгодог ёс бий. Өрхийн тоог гаргах нь түүнээс гарах цэрэг зэвсэг, агт морь зэрэг үйлдвэрлэлийн хэрэгслийн нөөц чадавхыг бүрдүүлж бэлчээрээ тэлэх, тогтоон барих, хамгаалах чадавхтай гэсэн үг. Өрх ийм нөөц чадавхгүй бол бэлчээрээ орхин нүүхээс аргагүй болдгийг Тайчууд нар Есүхэй баатарын отгийг орхин нүүсний дараа Өүлүн эх хүүхдүүд, үлдсэн цөөн тооны албат нараа Тайчуудыг хорслоо тайлж болзошгүй гэж үзэн Онон мөрний эх рүү дутаалгасан. Тэмүүжин энэ үед 9 настай ч өрхийн тэргүүн болсон юм. Нийтлэг нөөц буюу бэлчээр нь ийнхүү бүлгийн тэргүүн, зонхилогчтой байж гишүүддээ учирч болзошгүй эрсдэл бууруулах бас боломж олгох үүргийг гүйцэтгэдэг.

Уламжлалт нийгэмд засаг захиргааны нэгж болох хошуу нь төрийн албан тушаалтан ноён,

²⁷ Өрх гэр, өрх – Эр эм, үр хүүхдээс бүрэлдсэн гэр бүлийн бүтцийг өөртөө багтаасан, дээрээс нь гэрийн уугуул зарц,

харц (сүрэгчин, аягачин, шивэгчин, хамжлага) нарыг хамарсан нийлмэл бүтэц бүхий зохион байгуулалтын хэлбэр.

шашных нь шавь нар байв. Тэдний мэдэлд нийт мал сүргийн 70 орчим хувь оногдож байсан үе бий. Ялангуяа хүрээ хийдийн мал, хөрөнгийг жас гэнэ. Үүний аж ахуйн үүрэг асар их. Байгалийн гамшиг, аж ахуйн арга ажиллагааны хоцрогдсон арга барил, гадаад, дотоодын мөнгө хүүлэгч нарт малаа завшуулан үгүйрэн хоосорсон, хуримтлалгүй хүмүүст жасын мал өгч маллуулна. Ш.Нацагдорж “Сум, хамжлага, шавь ард” (Урангуа., 2017) бүтээлдээ Халх Монгол дахь Хүрээ хийдийн жасын үйл ажиллагааг хөндөн жасын мал хариулагч сүрэгчин ба хөлсний малчин нарын ялгааг нарийвчлан авч үзсэн. Хүрээ хийдийн жасаас малыг хариулахаар авагсад ба энэхүү хөлсний малчдаас ялгаатай нь мал хариулсны хөлс хэмээн тусгайлан авдаггүй, харин хариулсан малын ашиг шим, үс ноосыг ашиглах, ачлага уналгад эдлэх хэрэглэх эрх бүхий болдог биеэ даасан аж ахуйтан юм. Гэтэл хөлсний малчид бол их төлөв гар хоосон ядуучууд бөгөөд тэд хүрээ хийдтэй мал хариулах хөлс хүчээ шууд тодорхой хэлэлцэж малыг сүрэгчин нарын адил удаан бус харин богино хугацаагаар хариулахаар авдаг ажээ (Урангуа., 2017). Ийнхүү нийгмийн хөдөлмөрийн хуваарийг нарийсгах болон хяналтын үүрэгтэй төдийгүй аж ахуйтандаа эрхээ эдлэх боломжийг олгодог харилцан ашигтай харилцаа юм. Гэтэл хөлсний малчин өмчийн эрхгүй

учраас үүнтэй холбоотой бод малыг хөдөлмөрийн хэрэгсэл болгон ашиглах боломжгүй. “Сүм хийдийн жасуудын сүрэг хариулагчдаас уул авч хариулсан малын сүү шимээс их бага аль нэгэн хэмжээгээр авдгаас бус өөр нэмэгдэл албан татвар сүрэг хариулагчдаас авдаггүй байсан гэж баттай хэлж болно (Ш.Нацагдорж., 1972). Жасын малыг малчдад тавиулж нэг талаасаа албадлагын мэт боловч харилцан итгэлцэлд тогтдог нийгмийн капитал юм (Урангуа., 2017). Ийнхүү нэг талаас жасын малчин сүм хийдийн үйл ажиллагаанд шаардагдах малын гаралтай зүйлийг гаргаж өгдгөөс бусад талаараа бол аж ахуйгаа аль хүрээнд эрхлэхээ бие даан шийднэ. Ерөнхийдөө бүх мал хөдөлмөрийн зүйлийн шинжтэй боловч бод мал үйлдвэрийн хэрэгсэл болдог учраас монгол орны худалдааны томоохон замууд дайран өнгөрдөг газарзүйн таатай байршлаа ашиглан хойшоо Томск хот, урагшаа Чуулалт хаалга, Бээжин зэрэг хот руу тэмээн жин тээх ажил нийтлэг байв. Ер нь нийгмийн бүтцийг бүрдүүлэгч ангиудын хооронд эвлэршгүй тэмцэл бус харилцан итгэлцэл буюу гэрээт бус харилцаагаар Монголын нүүдлийн нийгмийн онцлог илэрнэ. Өмчийн хувьд үйлдвэрлэлийн хэрэгслээр дамжуулан мөлжлөгийн хэрэгсэл болдоггүй учраас хэдийгээр газрын эзэн нь угсаа залгамжлагч ноён, тайж, жас бүхий шавь, хутагтууд боловч харьяат ардууд нь албадлагын бус ёс

суртахууны үндсэн дээр захирагддаг онцлогтой.

Нийтлэг нөөц нь түүнд үйлдвэрийн хэрэгслээр дамжин хамааралтай болсон гишүүдийн хөдөлмөрийн хуваарийг нарийсгах, ажил эрхлэх эрх чөлөө нь нээлттэй байх боломжийг олгодог. ХХ зуун эхээр Монгол орон дэлхийн капиталист зах зээлийн харилцаанд байгалийн баялаг, мал аж ахуйн түүхий эдээр татагдан орж уламжлалт эдлэхүүний аж ахуйд өөрчлөлт орж эхэлжээ. Малчин ардуудын дотор хөрөнгө чинээний байдлын ялгаа нэмэгдэн мал хөрөнгө, эдийн засгийн хувьд чадал чинээ бүхий малчид олноор үүсэх болжээ. Зах зээлтэй холбоотой худалдааны төв, хилийн боомтуудад үүсдэг давуу тал, боломжуудыг ашиглаж байснаараа бусдаас ялгарч байв. Тэд уламжлалт нүүдлийн мал аж ахуйгаас гадна, жин тээх, газар, мал (хөсөг уналгын) түрээслэх, хадлан эрхлэх, мөнгө хүүллийг эрхлэх болсон байна. Монголын уламжлалт аж ахуйд шинэ аж ахуйн хэлбэр үүсэж, түүнийг эрхлэн хөтлөх хүмүүс ч бий болжээ. Гэвч энэхүү зүй ёсны хандлагыг Дэлхийн 2-р дайны дараах олон улсын нөхцөл байдалд зохицуулан өөрчлөхөд хүрсэн. ЗХУ зүүн зүгт Сибирийн бүс рүү нүүлгэсэн үйлдвэрлэлийн томоохон аж үйлдвэрлэлийн цогцолборуудыг түүхий эдээр хангах шаардлагын улмаас тухайн үеийн нам, төрийн удирдлага ардын аж ахуйтнуудыг хоршоолох, албан журмын татвар

тогтоон мал, малын түүхий эд бэлтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх болсон. “Эрх баригч нам, төр засгаас ардын хувийн аж ахуйтнуудад хоршоолол, хамтын аж ахуйн давуу талыг ойлгуулахын тулд ухуулга төдийгүй хамтран ажиллах янз бүрийн хэлбэрийг урамшуулах олон талын арга хэмжээг хэрэгжүүлжээ. Тухайлбал, 1955 оны 5 дугаар сард хуралдсан МАХН -ын Төв Хорооны II бүгд хурал намрын өвс хадлангийн ид ажлын үеэр ардын аж ахуйтны дотор харилцан туслалцах группүүд байгуулж ажиллуулах нь чухал гэж үзжээ. Зарим аймгийн малчдын хүсэлт санаачилгыг дэмжиж өвс хадах машин, багаж хэрэгслийг хамтран ашиглахад үнэ өртгийг нь хямдруулан худалдах шийдвэр гаргасан байна. Өвсний морин хадуур, тармуурыг 3-5 өрх дундаа авч хамтран эдлэхийг хүсвэл түүний үнийг 20 хувь, 6 буюу түүнээс дээш өрх хамтран эдлэх бол 25 хувь хямдруулан худалдаж байхаар Намын Төв Хорооны Бүгд хурал заасан байна” (Ж.Болдбаатар, БНМАУ-д ардын хувийн аж ахуйтныг хоршоолсон нь: бэрхшээл, зөрчил, үр дагавар (1950-1960-аад он), 2017).

Нэгдэлжих хөдөлгөөний нөхцөл дэх итгэлцэл (1959-1990-ээд он)

Судлаачид уламжлалт нүүдлийн хувийн мал аж ахуй өөрийгөө аргацаасан аж ахуй бөгөөд хөдөлмөрийн нарийн хуваарьгүй гэсэн үзэл хандлага түгээмэл. Хувийн мал аж ахуйн

хөдөлмөрөөрөө хорших хэлбэр нь хот айл, саахалт айлын зохион байгуулалт боловч бэлчээр ашиглалт хүн мал хүрэхэд төвөгтэй, зам харилцаа сул хөгжсөн зэргээс үүдэн хангалтгүй байв. Нэгдэлжих хөдөлгөөн нь мал аж ахуйг малыг нас хүйс, сүү мах, үржлийн гэх мэтээр ялган хөдөлмөрийн хорших хэлбэр бригад, суурь, хэсгээр зохион байгуулснаар өвөлжөө, хаваржааны хашаа хороо барьж малын зүй бус хорогдлыг бууруулахад эерэг нөлөөлжээ. Төрөөс хөдөлмөрөөр хоршсон 3-4 айл өрхөд хөнгөлөлттэй нөхцөлөөр трактор, хүнд техник хэрэгслийг олгож, мөнгө зээллэгийн онцгой давуу эрх олгож байсан нь нэгдэлжих хөдөлгөөнийг түргэсгэсэн байна. Ийнхүү хагас суурин буюу нэгдэл, бригадын төвүүд байгуулагдсанаар өвөлжөө хаваржаа барих, засварлах материаллаг бааз бэхэжсэн. Хагас суурин амьдралын хэв маяг нь малчдын гэр сууц томорч, эдлэл хэрэглэлийн овор хэмжээ ихсэж, өвс хадлан, хөрөнгө хогшлоо хадгалах хашаа хороотой болсноор алс хол отор нүүдэл хийх боломжийг нэмэгдүүлсэн байна. Нүүдлийн мал ахуйгаас гарвальтай харилцан итгэлцлийн үнэт зүйл нь тухайн үед шинээр нэвтэрсэн хүнд техник, хэрэгслийн оролцоотойгоор хөдөлмөрөөрөө хоршин нийгмийн нэн тэргүүн шийдвэрлэх хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтыг хангахад нөлөөлсөн нь дамжиггүй.

Нийгэмч хөдөлмөрийн үр дүнд худаг уст цэг, малын хашаа хороо, ариутгалын байгууламж, бригадын төв, сууриуд барьж байгуулагдан энэхүү хөдөлмөрийг тооцон цалин урамшууллын тогтолцоо буюу хөдөлмөр өдрийн хөлс олгох журам батлагдан мөрдөгдөж ирсэн. “Нэгдлийн өмч болох хүнд машин техник нь уламжлалт мал ахуйгаа эрхлэн хөтлөх технологийн нэг хэсэг болж хүний хөдөлмөрийг орлох түвшин хангалттай байж чадаагүйн улмаас яваандаа зардал ихтэй ашиг багатай зүйл болж хувирчээ” (Дашпүрэв. Д., 2022).

Аж ахуйн талууд дээд эрэмбийн зорилт нэгдэлжих хөдөлгөөний нөхцөлд хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж хүн амын хэрэгцээг хангах, гол нь эдийн засгийн нэгдсэн системд нэгдэн орсны хувьд ЗХУ-ын үйлдвэрлэлийн стандартад нийцсэн түүхий эдээр хангах явдал байв. Малчдаас мал, түүхий эдийг нийлүүлэх ажлыг гүйцэтгэхийн тулд малчдаас хямд үнээр авахаас өөр аргагүй байжээ. Тухайн үед улсын нийт бараа эргэлтийн 60 хувийг ердийн хөсгөөр гүйцэтгэж тээврийн зардал нь худалдааны зардлын 40 гаруй хувийг эзэлж байсан тул улсын бэлтгэлийн хүрээнд цугларсан мал, түүхий эдийг Зөвлөлтийн хилд үндсэн 4 чиглэлээр тээвэрлэн хүргэх зардлаас хямд үнээр худалдан авч байв.

Нэгдлийн гишүүн-малчид хашаа саравч барих, худаг ус гаргах,

хадлан тэжээл базаах, нүүх суух хөсөг унаагаа хүртэл нэгдлээр бэлтгүүлж, хаана нутаглах, хэзээ нүүх суухаа хүртэл дээрээс ямар шийд өгөхийг хүлээж суун, бэлэн үйлчилгээнд дассан нь малчдын бие даасан, идэвхтэй ажиллагааг алдагдуулж, нүүдлийн амьдралын олон үнэт зүйлс мартагдахад хүргэсэн (Ж.Болдбаатар, БНМАУ-д ардын хувийн аж ахуйтныг хоршоолсон нь: бэрхшээл, зөрчил, үр дагавар (1950-1960-аад он), 2017). Мал аж ахуйн машинт станцын тоног төхөөрөмж, техникийг үүрэг зориулалтаас нь гажуудуулж малчдын гар урлалын хүрээний эдлэл хэрэглэлийг үйлдвэрлэн хангах болсон. Хятадаас үйлдвэрийн аргаар хийсэн хямд төсөр эсгийтэй уламжлалт аргаар хийсэн Эсгий, эсгий эдлэл өрсөлдөж чадахгүй байна.

Мал, малаас гаралтай түүхий эдийн үнэ өсөөгүй, харин ЗХУ-аас нийлүүлэгдэж байгаа техник хэрэгсэл, хэрэглээний бүтээгдэхүүний үнэ тогтол өсөж байсан нь нийлүүлэлтийн хомсдолыг үүсгэв. Гэвч нүүдлийн аж ахуйн уян хатан цомхон технологи хадгалагдаж байгаа нөхцөлд хүнд техник нь зориулалтаараа ашиглагдах нь бий ч үндсэн үйл ажиллагаанд эрэг шураг болоогүйгээс сэлбэг хэрэгсэл, төхөөрөмжийн ханган нийлүүлэлтийн хувьд төвөөс хамааралтай, нийлүүлэлтийн дутагдалтай байдаг нь харилцаа холбоо тогтоох нутаг нугын гэсэн

уламжлалт харилцаа улам л бэхжихэд нөлөөлжээ (Bulag, 2016). 1978 онд БНМАУ-ын нийт нэгдлүүдийн нийт хөрөнгө оруулалт 326,2 сая төгрөг байснаас 208 сая нь өөрийн, 57,6 сая нь зээлийн, 60,6 сая нь улсын эх үүсвэр байв. 1970-78 оны хооронд 9 жилийн хугацаанд нэгдлүүд улсын банкнаас нийт 246 сая төгрөгийн зээл авч, тэрхүү авсан зээлээс 90 сая төгрөгийг эргэн төлөхөөс улсын дэмжлэгээр чөлөөлжээ (Алтантөгс Н. ба бусад., 2023). Энэхүү зээлийн эргэн төлөлтийг хөнгөлөхөд нэгдлийн удирдлагын хувийн харилцаа, хувь хүнийх нь идэвх чармайлт, төрийн байгууллага дахь танил тал, нутаг усны ах дүүсэг харилцаа ихэд нөлөөлсөн гэдэг. Анхан шатны хөдөлмөрийн шат дамжлага Нэмүү өртөг нь өөрт нь бус бусад салбарын хөрөнгө оруулалтад зарцуулагдсан. Дээд эрэмбийн зорилт хангагдсанаар доод эрэмбийн чанарт зохих өөрчлөлт гарах ёстой. Аж ахуйн хэрэгцээнд худалдан авсан техник тоног төхөөрөмжийг ашиглан олж байгаа ашиг туйлын хангалтгүй, зардал ихтэй, хүний хөдөлмөрийг орлон чөлөөлөхөд бус нүүдлийн арга ажиллагаа технологийн үйл явцад оролцож техникийн хувьд нутагшдаггүй байснаас малчид нэгэн хэвийн хүнд хөдөлмөр буюу түүхий эдийн хямд төсөр үнэ өртөгтэй бэлтгэн нийлүүлэх хөдөлмөрөөс салсангүй. эндээс олсон ашгаар нэмүү өртөг буюу

улам олон ажилчныг хөлслөх, улам сайн чанарын үйлдвэрлэлийн техник хэрэгслийг нэвтрүүлсэнгүй.

Системийн тогтвортой байдал нь гадаад орчны орчинтойгоо харилцан үйлдэлд оролцон мөн өөрийн нөхөн үйлдвэрлэлийг хангах бүтэц, үүргийн уялдаат тогтолцооноос хамаарна. Энэ тохиолдолд нэгдлийн үйлдвэрлэлийн хэрэгслийг ашиглах эрхээ эдэлснээр алс хол отор нүүдэл хийж бэлчээр ашиглах боломж нээгдэж байгаа хэдий ч амины малаа өсгөх, хэрэглээний зүйл үйлдвэрлэх, гар урлал эрхлэх зэрэг үе хоорондын соёлын өв хадгалан өвлүүлэх залгамж холбоо суларч ирсэн. Хэрэглээний зүйлээр хангагдаж байсан ч өрхийн доторх уламжлалт хөдөлмөрийн хуваарьт суурилсан хэрэгцээгээ хангах өрх гэрийн доторх хөдөлмөрийн нарийн хуваарь алдагдан хүүхэд эмэгтэйчүүдийн үүрэгт ажлыг хөдөлмөрийн үнэлгээнээс салгав. Малчдын өдөр тутмын хэрэглээний зүйлийн өртөг ба мал, малын түүхий эдийн арилжааны өртгийн хоорондын харьцаа тэгш бус учраас хөдөлмөрийн өртөг болох цалин нь ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийг хангахгүй болсон. “Нэг сард тус бүртээ хамгийн ихдээ 131 төгрөгийн цалин авч буй хөлсний малчин эхнэр, нөхөр 2 хүн өрх гэрийнхээ хоол хүнс, хувцас, дулааны зардлыг хангаж чадах эсэх нь тун эргэлзээтэй. Учир нь 131 төгрөгөөр 131 кг гурил авч чадах билээ. Бие өвдөх, амаржих, чөлөө

авах, амралтаа эдлэх, хурал зөвлөгөөнд оролцох зэргээр үйлдвэрлэлээс цөөн хоногоор хөндийрмөгц үйлдвэрлэлийн даалгавар тасалдах эрсдэл үүснэ (Алтантөгс Н. ба бусад., 2023) Нэгдлийн өмч болох үйлдвэрлэлийн хэрэгслийг ашиглан хэдий маш бага цалин хөлс авч байгаа ч амины малаа өсгөх боломж байсан. Гэвч нэгдлийн малыг үхүүлж үрэгдүүлбэл амины малаас нь нөхөн авдаг байдал түүнд тулгуурлах өрхийн хэрэгцээт хэрэглээний зүйлээ үйлдвэрлэх боломжийг өгсөнгүй. Хүн өөрийнхөө нөөц чадавхыг ашиглан сонголт хийхийн тулд хэрэглээний хамгийн энгийн нөхцөлийг бүрдүүлсэн байх нь эрх чөлөө юм (Амартия, 2014). Ийнхүү үйлдвэрийн хэрэгслийг ашиглан бэлчээрээ тэлэн ашиглах эрхтэй болж байгаа мэт боловч амины малд тогтоосон тооны хязгаарлалт, нэгдлийн малаас ялгаж тусад нь хариулахын тулд зөвшөөрөл авч заасан газрыг л ашиглах ёстой байсан зэрэг нь хөдөлмөрийн хөлс нь тэдний ажиллах хүчний өртгөөс багаар тогтоогдож байгаа нөхцөлд тэрхүү бичил аж ахуйнхаа ачаар ажиллах хүчийг бий болгоход шаардлагатай өртгийн дутуу үлдсэн хэсгийг нөхдөг байжээ (Алтантөгс Н. ба бусад., 2023)

Гэр ахуйн эдлэл хэрэглэлийн хэмжээ үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болсонтой холбоотой овор хэмжээ ихтэй болсноор ердийн хөсөг, тэмээн жин ашиглах шаардлагагүй болов. Нүүдлийн мал

аж ахуйн онцлог нь ашиг олох арилжааны шинжээр хязгаарлагдахгүй малчин хүнд малын өнгө зүс байгаль дэлхийн өнгө төрхтэй нийцэл зохицолтой байх гоо зүйн, мал адгуусыг хайрлан энэрэх ёс зүйн, юмхнаар юм хийх ур дүйн мэдлэг ухаан хадгалагдаж иржээ.

“1967 оны байдлаар Гэрэлт зам нэгдлийн суурийн хүн амын бүтцээс үзвэл нийт 1032 малчин, 1188 хүүхэд, хөгшид байх ба нэг малчны цаана 1,1 хүүхэд хөгшид байна. Энэ нь Монголын уламжлалт бүтцээс огт өөр бөгөөд суурь дээр хүүхэд хөгшид эрс цөөн байсныг харуулна. Чухамхүү сум-нэгдлийн тогтолцоо бий болсон үеэс малчдын хүүхдүүд хөдөлмөрийн чадвар муутай өвөө эмээ нарын хамт буюу эсхүл сургуулийн дотуур байранд, жилийн ихэнх хугацааг сургуульд сууж өнгөрүүлж, сум нэгдлийн төв дээр бүртгэгдэх болсонтой холбоотой бололтой (Алтантөгс Н. ба бусад., 2023). Улсын хэмжээнд малчин өрхийн тоог цөөрүүлж, нэг малчинд оногдох малын тоог боломжит хэмжээнд хүргэж нэмэгдүүлж чадвал МАА-н бүтээгдэхүүний өөрийн өртөг багасаж, цэвэр ашиг мөн ихсэх боломжтой“ (Алтантөгс Н. ба бусад., 2023) Суурийг малын зүс, ашиг шим мэтээр малчдын хөдөлмөрийн хуваарийг хатуу баримтлан уламжлалт өрх айлын харилцан туслалцдаг, тодорхой шижмээр холбогдсон хот айлын

тогтолцоо алдагдсанаар өрхийн гишүүд ажил үүргийн хувьд харилцан нэгнээ орлох боломжгүй болов. Алс хол жин тээхээр явахад ажил үүргээ үлдсэн айлуудаас өрхүүдэд шилжүүлэн ажиллах хүчний дутагдлаа нөхөх боломжтой байв.

Ийнхүү малчдын хөдөлмөрийн хөлсийг ажиллах хүчний өртгөөс нь доогуур тогтоосноор нэмүү өртөг нэгдлийн ашиг болон хувирч байв. Сум нэгдлүүд нэмүү өртгийг хуримтлуулсны үр дүнд сумын захиргаа, эмнэлэг, нэгдэл дундын үйлдвэрийг байгуулж, санхүүжүүлж, сумын албан хаагчдыг цалинжуулж байв. Ийнхүү үйлдвэрийн хэрэгсэл нь нийтлэг нөөц болох бэлчээрийн хэмжээг нэмэгдүүлсэн ч хэт явцуу хөдөлмөрийн хуваарь, ажиллах хүчний өртгөөс нь бага цалин хөлс, нийгмийн суурь үйлчилгээ авч чадахааргүй амралтгүй шахам ажил хөдөлмөр нь малчид амьдралын чанарт эергээр нөлөөлөх учиртай дээрх бүтээн байгуулсан нийгмийн дэд бүтэц, удирдлагын нөөцийн үр нөлөөг хүртэлгүй байсаар нэгдэл тарсан билээ.

Нэгдэл тарсны дараах үеийн итгэлцлийн харилцаа

Хүч чадал сайтай баян тансаг хувийн эзэмшлүүд үүсэж бий болох нь нүүдэлчин малчдын аж ахуйн хөгжлийн хандлагын шинж чанартай болох бөгөөд үүний улмаас чинээлэг аж ахуйтнууд ядуучуудаа далдуур мөлжих уламжлалт хэлбэрүүд гарч ирэх

болно. 1990 оноос хойш нэгдлийн зохион байгуулалтыг хувийн аж ахуйнууд болгон задалсанаар "... арваад хувийн аж ахуй хөлсний ажиллах хүчний журмаар биш харин харилцан ашигтай туслалцаа үзүүлэх маягаар бусад хувийн аж ахуйн ажиллах хүчийг ашигладаг болчихоод байж билээ (Дашпүрэв. Д., 2022). Харин нэг түвшний нөөц ашиглагчид буюу бэлчээрийн мал аж эрхлэгчдийн хооронд өөрийн хүч хөрөнгө хүрэлцээгүй байдлаа бусад аж ахуй эрхлэгчидтэй албан бусаар тохиролцох замаар хөдөлмөр, техник хэрэгсэл, уналга эдэлгээний үнэ хөлсийг тохиролцох нь тогтвортой удаан хугацаанд үйл ажиллагаа явуулах нөөц хөрөнгө, техникийн боломжийг бүрдүүлдэггүй. Ах дүүс, хамаатан садан төрлийн аж ахуй эрхлэгчид харилцан туслалцахаас цааргалахгүй ч аливаа төрлийн үйлчилгээ болон техникийн туслалцаа үзүүлсний хөлс зах зээлийн үнэ ханш биш нь мэдээж билээ.

Монголын нүүдлийн мал аж ахуй нь өөрийгөө аргацаасан байдлаас хөдөлмөрөө нэгтгэн хамтач аж ахуй болох нь цаг хугацааны асуудал төдийгүй эрин үеийн шаардлага юм. Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран эзэмшиж болно (Land Law., 2002). Гэвч бэлчээрийн газрын хэмжээг нарийн тогтоох боломжгүй учраас хаяа залган өөр иргэн, хот айл шинээр өвөлжөө барьж эзэмшил үүсгэснээр

бэлчээрлэх газрын хэмжээ хумигддаг. Энэ заалт бодит амьдралд олон эерэг сөрөг талуудтай. Малчид өвөлжөөгөө албан ёсны болгож байгаа ч түүнийхээ үнэ цэнийг алдах эрсдэлд ордог. Өөр хэн нэгэн зэргэлдээ нь өвөлжөө бариад бэлчээрийн талбайг хумих вий гэсэн болгоомжлол, үл итгэлцэл малаа тооны хувьд өсгөж аль болох тэр хавийнхаа бэлчээрт өөр айлын мал бэлчээрлэх аргагүй болтол нь идүүлдэг байна (Бямбабаатар И., 2022). Нийтлэг нөөцийн онцлог нь түүнээс ашиг хүртэгсдийн аль нэгний давуу боломж нөгөөгийн түүнээс хүртэх боломжийг хязгаарладаг (Ostrom, 1961). Малын гаралтай түүхий эдийн үнэ бага байгаа нөхцөлд хэвтээ чиглэлийн эрэмбийн өрсөлдөөн нь аль болох олон малтай байх замаар зардал хэмнэдэг бэлчээрийн даац хэтрэлтэд хүргэнэ нийтээрээ хохирдог.

Өвөлжөөний суурин хөрөнгө нь хөрөнгийн баталгаа болдог учраас малчдын бүлгүүд хөгжлийн хөтөлбөрт хамрагдан техникийн туслалцаа авах, банкны зээллэгт хамрагдах боломжтой. Айл өрх бүрд үйлдвэрлэл эрхлэхэд эрчим хүч, хүний нөөц, өндөр зэрэглэлийн замын сүлжээ барих өртөг өндөр учраас эдгээр нөөцийг тооцож бүсчлэн хөгжүүлэх шаардлагатай юм.


ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нэхмэлийн салбарт анхан шатны боловсруулалтын кластерын байршлын төвлөрлийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг тооцсон байна (Одмаа П., 2016). Үүнд:

- Байршлын коэффициентийн арга – Location Quotients
- Монгол улсын 332 сумдын статистик мэдээлэл

- Хүн амын тоо
- Түүхий эдийн нөөцийн хэмжээ
- Замын нөхцөл /хатуу хучилттай замаас алслагдсан зай, км/
- Эрчим хүч /эрчим хүчний системд холбогдсон байдал;
- ArcGis программ хангамж
- Бүс нутгийн сонголт

Зураг 1. Ноолуурын нөөцийн нэгтгэсэн үзүүлэлт. Төвлөрлийг үнэлэх хүчин зүйлсийн шалгуур утгуудаар кластерын байршлыг тогтоосон



Эх сурвалж: Одмаа П.Нэхмэлийн салбарт аж үйлдвэрийн кластерийг хөгжүүлэх асуудал

Зураг 2. Ноосны нөөцийн нэгтгэсэн үзүүлэлт. Төвлөрлийг үнэлэх хүчин зүйлсийн шалгуур утгуудаар кластерын байршлыг тогтоосон



Эх сурвалж: Одмаа П.Нэхмэлийн салбарт аж үйлдвэрийн кластерийг хөгжүүлэх асуудал

Сүүлийн жилүүдэд бэлчээрийн доройтол, байгалийн гамшгийн давтамж нэмэгдэж байгаагаас малчдын мал аж ахуйн хөдөлмөр эрхлэх эрх чөлөө хумигдан төв суурин бараадах сонголт үлддэг.

Үйлдвэрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах нь уламжлалт нүүдлийн арга ажиллагаа, технологитой зохицон уялдаж байж л үр ашигтай, зардал багатай болохыг нэгдлийн түүхэн туршлага харууллаа. Өнөө

үед ноос ноолуурын салбарт гүн боловсруулалт хийж байж л дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлнэ.

Орон нутагт анхан шатны боловсруулалт хийх өөр аргагүй ч самнах үйлдвэрүүдийн хүч чадал дутагдалтай, ихэнхдээ угаах үйлдвэрүүдтэй. Угаасан ноос, ноолуураа УБ хот руу самнах үйлдвэрт тушаадаг боловч тээвэрлэлтийн зардал нь өртгийг 50 орчим хувиар нэмэгдүүлж байна. Самнах үйлдвэрлэлд хөрөнгө оруулахгүй бол дараагийн шат буюу ээрэх, нэхэх зэрэг үйлдвэрлэлийн гүн боловсруулалт хийн өндөр үнэ төлөх чадвартай хэрэглэгчдийн зах зээлд нэвтрэхэд сөргөөр нөлөөлж байна. Хэрвээ хамгийн нарийн ширхэгтэй, эрүүл мэндэд нэн тохиромжтой, байгаль, малдаа ээлтэй аргаар бэлтгэгддэг ноолууртай онцлогоо харгалзвал Итали, франц зэрэг өндөр технологи бүхий орнууд руу хийж байгаа экспортоо нэмэгдүүлнэ (Одмаа П., 2016) гэсэн дүгнэлт оновчтой юм.

Ноос ноолуурын салбарт анхан шатны боловсруулалтын хөрөнгө оруулалт нь нүүдлийн МАА-н өртөг зардал багатай авсаархан технологид зохицсон ажиллах хүчний нөөцийн оновчтой хуваарилалттай, улирлын чанартай шилжин ажиллахад нийцсэн хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэр оновчтой юм. Үүнд нь мал ахуйн хөдөлмөр зохион байгуулалтын олон төрлийн хэлбэр,

бүтэцтэй байж болох ч тухайн нөхцөлд тохирох чиг үүргээ орлох боломжтой өрх айлуудын бүлэг болох хот айлын уламжлалт харилцааг хадгалсан нүүдлийн мал ахуйн хөдөлмөр зохион байгуулалтыг харгалзахыг санал болгож байна.

ДҮГНЭЛТ

1. Дээрх 3 үеийн нийтлэг шинж дараах онцлогоор илэрч байна. Дээд эрэмбийн зорилт үйлдвэрийн хэрэгслийн хуваарилалт, хяналтын эргэх холбоогоор хангагддаг. Дэд эрэмбийн хүрээний нөөцийн ашиглалтыг хуваарилах эрх мэдэл нь бүлгийн хүрээнд хөдөлмөр зохион байгуулалт (өрх айл, суурь бригад, малчдын бүлэг)-ыг дээд эрэмбийн зорилтыг хангах шаардлагын улмаас үүсэн тогтворжиж ирсэн. Эсрэгээр уг эрэмбийн түвшинд тохирсон технологитой нөөц ашиглагчдын хоорондын өрсөлдөөн нь нийтлэг нөөцийн “эмгэнэл”-д хүргэдэг. Үйлдвэрийн хэрэгслийн хяналт нь дээд эрэмбийн зорилтыг хангахдаа дэд эрэмбийн үйлдвэрлэлийн технологид тохирсон нөхцөлд л нийтлэг нөөц ашиглах үйл ажиллагааг төрөлжүүлэх боломжийг бүрдүүлдэг. ХХ зууны эхэн болоход цайны замын дагуу худалдааны жин тээх, өртөө улааны ажлыг малчид нугалж байв.

2. Нэгдэлжих замаар малыг нас хүйс, үйлдвэрлэлийн түүхий эд бэлтгэлийн шинжээр төрөлжүүлсэн сайн талтай ч бэлчээрийн газрын

маргааныг зогсоогоогүй. Учир нь нийтлэг нөөцийн ашиглалт нь олон төрлийн мал сүргийг чөлөөтэй сэлгэн адгуулах уламжлалт аргаас үүдэлтэй. Бэлчээрийн мал аж ахуйн арга ажиллагаанд өртөг, арчилгааны зардал ихтэй хүнд техник, хэрэгсэл нэгдлийн ашгийн өсөлтийг хязгаарласан. Үйлдвэрийн хэрэгслийг эзэмших нэгдэл, хоршооллын өмчийн эрхийн бүртгэл нь малчид хэрэгцээт зүйлээ уламжлалт технологийн хүрээнд үйлдвэрлэж ирсэн уламжлал тасрахад хүрсэн. Хот айлын гишүүдэд хамаатай төл бойжуулах, малын түүхий эд, байгалийн бусад дагалдах нөөц бэлтгэхийг “Хөдөлмөр өдрийн хөлс олгох журам”-аар албан хөдөлмөрт тооцсоноор ажиллах хүчний нөөц

хомсодсон.

3. Ноос ноолуурын анхан шатны боловсруулалт хийлгүй улирлын чанартай үнийн өсөлтөд найдан хонь, ямаа өсгөх нь зардал багатай ч нийтлэг нөөц болох бэлчээрийн доройтолд хүргэн нийтийн эзэмшлийн эмгэнэлд ч хүрч болзошгүй.

4. Дэд эрэмбийн түвшний буюу бэлчээр ашиглагчдын үйлдвэрлэлийн хэрэгслийн хөрөнгө оруулалт нь хувийн мал аж ахуйтны боломжоос хэтийдэх тул дээд эрэмбийн үйлдвэрлэлийн зорилтыг хангах дэд бүтэц, эрчим хүч, ажиллах хүчний нөөцийн хүчин зүйлсийг тооцсон кластер байршлуудыг тогтоосноор хангагдах бололцоотой юм.

НОМ ЗҮЙ

[1]. Д. Дашпүрэв., Монгол нийгэм., Улаанбаатар.: "Сэлэнгэ пресс" ХХК, 2017.

[2]. Н. Хавх., Монголчуудын нүүдлийн мал аж ахуйн гүн ухаан., Улаанбаатар: Бит Сервис. ХХК, 2000.

[3]. Ostrom, Common pool resource., NY., 1961.

[4]. Н. Б. Батцэрэн Ц., Инженерийн ёс зүй., Улаанбаатар: Гэрэлт судар Паблишинг, 2019.

[5]. Ж. Урангуа., "Монголын мал аж ахуйн түүхийн судалгааны тойм.,” ХХ ЗУУНЫ МОНГОЛ: ТҮҮХ, СОЁЛ, ГЕОПОЛИТИК, ГАДААД ХАРИЛЦААНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД., pp. 202-236, 2017.

[6]. Ш.Нацагдорж., Сум, хамжлага, шавь ард., Улаанбаатар, 1972, pp. 76-81.

[7]. Ж.Болдбаатар, "БНМАУ-д ардын хувийн аж ахуйтныг хоршоолсон нь: бэрхшээл, зөрчил, үр дагавар (1950-

1960-аад он),” ХХ ЗУУНЫ МОНГОЛ: ТҮҮХ, СОЁЛ, ГЕОПОЛИТИК, ГАДААД ХАРИЛЦААНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД., pp. 179-201, 2017.

[8]. Д. Дашпүрэв., Монголын нийгмийн шинэчлэлтийн үе шатууд, Улаанбаатар: Соёмбо принтинг, 2022.

[9]. E. U. Bulag, Nationalism and Hybridity in Mongolia., Ulaanbaatar: Soyombo printing., 2016.

[10]. Алтантөгс Н. ба бусад., "Сум-нэгдлийн тогтолцоо," in Сум нэгдлийн малчдын мал аж ахуйн үйлдвэрлэл, Улаанбаатар, Соёмбо принтинг ХХК., 2023, pp. 185-240.

[11]. С. Амартя, Хөгжил бол эрх чөлөө, Улаанбаатар: Непко, 2014.

[12]. "Land Law.," 07 2002. [Online]. Available: <https://legalinfo.mn/mn/edtl/16231470738171>.

[13]. Бямбабаатар И., Хөгжлийн эрэлд: Мал аж ахуй, байгаль хамгаалах салбар дахь хөгжлийн байгууллагын хөндлөнгийн оролцоо, Улаанбаатар, 2022.

[14]. Одмаа П., "Нэхмэлийн салбарт аж үйлдвэрийн кластерыг хөгжүүлэх асуудал. Бизнесийн удирдлагын ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл," Улаанбаатар, 2016.